



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 11/180

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 3 дугаар хуралдааны А/19 тогтоол Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аравтын зохион байгуулалттай "Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, гишүүдийн оролцоог сайжруулах чиглэлээр" гэрээнд заагдсан сэдвийн хүрээнд орох сургалтын зардалд 1.200.000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын "Аравтын зохион байгуулалттай байгалын нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих дэд хөтөлбөрөөс санхүүжүүлэхийн нягтлан бодогч (Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Г.ЭНХЗАЯА